

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Бигэр сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2023/07/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Алтай хот
2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр	
Утас: 70483413	Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг	
Утас: 70484055	Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
Ахлах аудитор	Б.Цэвэлмаа
Утас 99026016	Цахим хаяг: tsevelmaab@audit.gov.mn
Аудитор	М.Дөлгөөнбаяр
Утас: 85151215	Цахим хаяг: dulguunbayarkh@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мянган төгрөг/

	Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	159,570.1	218,614.1
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,411,938.7	2,563,488.3
	Нийт хөрөнгийн дүн	1,571,508.8	2,782,102.4
	Нийт өр төлбөрийн дүн		
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,571,508.8	2,782,102.4
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,571,508.8	2,782,102.4
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,076,098.6	1,816,790.1
	Үйл ажиллагааны зардлын дүн	448,075.1	587,040.8
	Үйл ажиллагааны үр дүн	628,023.6	1,229,749.3
	Үйл ажиллагааны бус үр дүн	- 30,043.7	- 19,155.7
	Үйл ажиллагааны нийт үр дүн	597,979.9	1,210,593.6
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	973,528.9	1,571,508.8
	Тайлант оны үр дүн	597,979.9	1,210,593.6
	Эцсийн үлдэгдэл	1,571,508.8	2,782,102.4
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	387,901.3	484,513.0
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	385,701.3	414,369.5
	Үйл ажиллагааны ЦМГ	2,200.0	70,143.5
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	- 2,200.0	- 70,143.5
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	314,763.5	420,943.0
	Урсгал зардал	314,763.5	350,943.0
	Хөрөнгийн зардал	-	70,000.0
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	314,763.5	420,943.0
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	314,763.5	420,943.0
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 65.4 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгасан.

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:

Төсвөөс үндсэн хөрөнгө бэлтгэхээр 62.1 сая төгрөг шилжүүлж, хүлээн аваагүй хөрөнгийг орлогоор бүртгэсэн, санхүүгийн үр дүнгийн тайланд цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 3.3 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь "Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон

улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" заалтыг тус тус зөрчсөн байна.

Аудитаар нийт 48.9 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 8.1 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 18.9 сая төгрөгийн зөрчилд сахилгын хариуцлага тооцуулах тухай 1 заалт албан шаардлага, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 5 заалт 21.9 сая төгрөгийн албан шаардлага, 1 заалт зөвлөмж хүргүүлсэн.

3.1 Төлбөрийн акт

- ✓ Ажилчдын амралтын цалинг үндсэн цалинтай давхардуулан 0.7 сая төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно" гэж заасныг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Ажлаас чөлөөлөгдсөн Засаг даргын орлогчид үндэслэлгүйгээр 5.2 сая төгрөгийн тэтгэмж олгож төсөв хохироосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын хуулийн 78 дугаар зүйлийн 78.1-т "Аймаг, сум, нийслэл, дүүргийн Хурлын дарга болон бүх шатны Засаг дарга ээлжит сонгуулийн дүнд албан тушаалаасаа чөлөөлөгдсөн бол тэдгээрт урьд нь эрхэлж байсан албан тушаалын зургаан сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгоно." гэж заасныг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж Засаг даргын нөөц хөрөнгөөс элсэлтийн ерөнхий шалгалтад амжилт гаргасан сурагчдад шагнал 0.1 сая төгрөг, тэмцээн уралдааны шагналд 1.2 сая төгрөг, гавьяат алдартнуудад хүндэтгэл үзүүлэхэд 0.8 сая төгрөг нийт 2.1 сая төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах"; Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоолын 5 дугаар зүйлийн 5.4.-т "бүх шатны төсвийн байгууллагын гадаад албан томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах, тавилга, эд хогшил, ном хэвлэл худалдан авах болон хэвлүүлэх, сурталчилгаа хийх, бэлэг дурсгалын зүйлс бэлтгэх, биеийн тамирын уралдаан тэмцээн, салбарын болон байгууллагын тэмдэглэлт ой, баяр ёслолын арга хэмжээ зохион байгуулах, салбартай холбоотой киноны уран бүтээл хийх, төрийн захиргааны төв байгууллагуудын тээвэр, шатахууны зардал, төрийн тусгай чиг үүргийн байгууллагаас бусад төрийн байгууллагууд шинээр автомашин худалдан авах зардал, захиргааны албан контор шинээр барих зардлыг тус тус 100 хувь, бүх шатны төрийн байгууллагын бичиг хэргийн зардлыг 50 хувь, коронавируст халдварын цар тахалтай тэмцэж байгаа эрүүл мэнд, онцгой байдал, цагдаа, мэргэжлийн хяналт, хил, гаалийн байгууллагаас бусад бүх шатны төрийн байгууллагын дотоод албан томилолтын зардлыг 50 хувь тус тус хэмнэх чиглэл баримтлах" гэж заасныг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Албан шаардлага

- ✓ Засаг даргын нөөц хөрөнгөөс аймгийн аварга малчны шагнал арга хэмжээнд 3.2 сая төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоолын 5 дугаар зүйлийн 5.4.-т "бүх шатны төсвийн байгууллагын гадаад албан томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах, тавилга, эд хогшил, ном хэвлэл худалдан авах болон хэвлүүлэх, сурталчилгаа хийх, бэлэг дурсгалын зүйлс бэлтгэх, биеийн тамирын уралдаан тэмцээн, салбарын болон байгууллагын тэмдэглэлт ой, баяр ёслолын арга хэмжээ зохион байгуулах, салбартай холбоотой киноны уран бүтээл хийх, төрийн захиргааны төв байгууллагуудын тээвэр, шатахууны зардал, төрийн тусгай чиг үүргийн байгууллагаас бусад төрийн байгууллагууд шинээр автомашин худалдан авах зардал, захиргааны албан контор шинээр барих зардлыг тус тус 100 хувь, бүх шатны төрийн байгууллагын бичиг хэргийн зардлыг 50 хувь, коронавируст халдварын цар тахалтай тэмцэж байгаа эрүүл мэнд, онцгой байдал, цагдаа, мэргэжлийн хяналт, хил, гаалийн байгууллагаас бусад бүх шатны төрийн байгууллагын дотоод албан томилолтын зардлыг 50 хувь тус тус хэмнэх чиглэл баримтлах", гэж заасантай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Малжуулалтын гэрээний хугацаа дууссан 18.0 сая төгрөгийн 30 толгой малыг дараагийн айлд шилжүүлээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ": Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1-т "эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах;" Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр малжуулах гэрээний 2.1 дэх хэсэгт малжуулалтаар авсан малыг гэрээний хугацааны дагуу тоо толгойгоор нь дараагийн өрхөд бүрэн хүлээлгэж өгнө" гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ "Тэгштайшир групп" ХХК-тай байгуулсан 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 2019/09 дугаартай сумын жишиг гудамж хийх ажлын гэрээний хугацаа дууссан боловч одоог хүртэл хүлээж аваагүй, "Мөнгөн минж" ХХК-тай байгуулсан 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 2022/13 дугаартай Мянгай бургасны услалтын системийн засвар шинэчлэлийн зураг төсөл хийх ажлын гэрээний хугацаа дууссан боловч ажлыг хүлээж аваагүй байгаа нь "Тэгштайшир групп" ХХК-тай байгуулсан 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 2019/09 дугаартай гэрээ, "Мөнгөн минж" ХХК-тай байгуулсан 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 2022/13 дугаартай гэрээний биелэлтийг хангуулаагүй, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ "Энх-Өргөө ХХК"-тай байгуулсан 2019 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн АОНТ-01 дугаартай гэрээний дагуу 5-р багт шинээр хөв байгуулах ажлыг шүүхэд хандсан боловч дараагийн шатны арга хэмжээг аваагүй байгаа нь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 133/ШШ2021/00310 дугаар захирамжийг хэрэгжүүлээгүй, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн нягтлан бодогчийн ажлыг хавсран гүйцэтгэсний нэмэгдэл 0.6 сая төгрөгийг авсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх хэсэгт төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; Сангийн сайдын 2021 оны 86

дугаар тушаалаар батлагдсан Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 8.6-д "Энэхүү журмын 8.5-д заасан санхүүжилтийн эрхийн дагуу ОНХС-ийн төрийн сан дахь данснаас гүйлгээ хийх төлбөрийн хүсэлтийн баримтад сум дүүргийн хувьд 1 дүгээр гарын үсгийг төсвийн ерөнхийлөн захирагчийн эрх шилжүүлсэн албан тушаалтан, 2 дугаар гарын үсгийг Засаг даргын Тамгын газрын ахлах нягтлан бодогч тус тус зурна." гэж заасныг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Сахилгын хариуцлага тооцуулах тухай албан шаардлага

- ✓ Жолоочийн замын хуудасгүй, 2.8 сая төгрөгийн шатахуун зарцуулсан, нэмэлт санхүүжилтийн данснаас 16.2 сая төгрөгийг жимсний үнэ гэж шилжүүлж шууд зардлаар тайлагнасан, зарцуулалтад хяналт тавиагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13-т "албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах; гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Хууль тогтоомжтой холбоотой

Илрүүлэлт: Байгууллагын авто тээврийн хэрэгсэл нь бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглээгүй байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ"-ыг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын эзэмшин ашиглаж байгаа авто тээврийн хэрэгслийг тод өнгийн дэвсгэр бүхий улсын дугаартай болгох ажлыг зохион байгуулах.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Говь- Алтай аймгийн Бигэр сумын Засаг даргын Тамгын газар	2	65.4	-	-	1	65.4	1	65.4	-	-	-	-
Дүн	2	65.4			1	65.4	1	65.4				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ сая төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Дүн	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Говь-Алтай аймгийн Бигэр сумын Засаг даргын Тамгын газар	11	48.9	4	8.1	5	21.9			18.9	1	-	-
Дүн	11	48.9	4	8.1	5	21.9			18.9	1	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Говь-Алтай аймгийн Бигэр сумын Засаг даргын Тамгын газар	1	-	-	-	-	-	1	-
Нийт дүн	1	-	-	-	-	-	1	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1	-	-	-	1	-	-
	НИЙТ	1	1	-	-	-	1	-	-